

## **ЗАСГИЙН ГАЗРЫН ҮНЭТ ЦААСНЫ АНХДАГЧ ЗАХ ЗЭЭЛИЙН АРИЛЖААГ ЗОХИОН БАЙГУУЛАХ ЗААВАР**

### **Нэг. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ**

1. Энэхүү зааврын зорилго нь “Монголын хөрөнгийн бирж” ТӨХК /цаашид МХБ гэх/- иар дамжуулан Засгийн газраас олон нийтэд санал болгон гаргасан үнэт цаасны анхдагч зах зээлийн арилжааг зохион байгуулахтай холбоотой харилцааг зохицуулахад оршино.
2. Энэхүү харилцаанд Үнэт цаасны зах зээлийн тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомж, Монгол Улсын Засгийн газрын “Засгийн газрын үнэт цаас гаргах, арилжих журам”-ыг удирдлага болгоно.
3. Энэхүү зааварт хэрэглэсэн нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно:
  - 3.1. Тогтоосон үнээр санал болгох арилжаа гэж Үнэт цаас гаргагчийн тогтоосон үнээр санал болгон арилжих үйл ажиллагаа;
  - 3.2. “Хүү хуримтлуулж эхлэх өдөр” гэж ЗГҮЦ-нд хүү тооцож эхлэх өдрийг эсхүл төлбөр тооцоо хийх өдөр нь арилжаа явагдсан өдрөөс хойш бол үнэт цаасны төлбөр тооцоо хийх өдрийг;
  - 3.3. “Төлбөр тооцооны өдөр” гэж ЗГҮЦ-ны арилжаагаар худалдан авсан үнэт цаасны төлбөрийг гүйцэтгэх өдрийг;
4. Арилжаанд зөвхөн СЗХ-ноос Үнэт цаасны зах зээл дээр мэргэжлийн ажил үйлчилгээ явуулах тусгай зөвшөөрөл авсан, МХБ-ийн гишүүн үнэт цаасны компаниар дамжуулан оролцоно.

### **Хоёр. ТОГТООСОН ҮНЭЭР САНАЛ БОЛГОХ АРИЛЖАА**

5. Үнэт цаас гаргагч Монгол Улсын Сангийн яамны үнэт цаас бүртгүүлэх өргөдлийг үндэслэн Засгийн газрын үнэт цаасыг бүртгэх, тогтоосон үнээр олон нийтэд санал болгон анхдагч зах зээлд арилжих тухай МХБ-ийн гүйцэтгэх захирлын шийдвэр гарна. Уг шийдвэрийг үндэслэн “Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК-д үнэт цаас хадгалуулах мэдэгдэл хүргүүлнэ.
6. Үнэт цаасны компани нь тогтоосон үнээс өндөр эсвэл доогуур үнээр ЗГҮЦ худалдан авах захиалга өгч болохгүй.

7. Үнэт цаасны компани нь өөрийн болон харилцагчийн захиалгыг МIТ системд долоо хоног бүрийн Мягмар гарагт 10.00-11.30 цагийн хооронд оруулах боломжтой байна.

8. Үнэт цаасны компани нь өөрийн болон харилцагчийн захиалгыг арилжааны программд оруулах хугацаа дууссаны дараа МХБ нийт худалдан авах захиалгын жагсаалтыг үнэт цаас гаргагч Сангийн яаманд хүргүүлэх ба хуваарилалтыг Сангийн яам хийнэ.

9. Үнэт цаас гаргагчаас ирүүлсэн нөхцлийн дагуу нэг харилцагчийн ЗГҮЦ худалдан авах захиалгын дээд хэмжээг заасан хязгаарлалтыг хийж болно.

10. МХБ нь дараа долоо хоногт арилжаалах ЗГҮЦ-ны хүүгийн хэмжээг долоо хоног бүрийн Баасан гарагт [www.mse.mn](http://www.mse.mn) цахим хуудсанд мэдээлнэ.

11. Арилжааг эрчим хүчний түр саатал, техник програм хангамжийн гэмтэл болон бусад давагдашгүй хүчин зүйлээс шалтгаалан цуцалж болно.

12. Арилжааг цуцалсан тохиолдолд үнэт цаас гаргагч арилжаа зохион байгуулагчаар дамжуулан дараагийн арилжаа явагдах огноо, цагийг мэдэгдэнэ.

#### Гурав. ТӨЛБӨР ТООЦОО

13. Хөрөнгө оруулагч ЗГҮЦ-ны төлбөрийг арилжааны шимтгэлийн хамт Арилжааны төлбөр тооцоо /АТТ/ дахь өөрийн нэрийн 12 оронтой дансыг зааж арилжааны банкаар дамжуулан АТТ-ны дансанд урьдчилан байршуулна.

#### Дөрөв. БУСАД

14. Арилжаа явагдсан өдөр бүр ЗГҮЦ-ны анхдагч зах зээлийн арилжааны мэдээг олон нийтэд МХБ-ийн [www.mse.mn](http://www.mse.mn) вэб сайтаар дамжуулан тогтмол хүргэнэ.

15. ЗГҮЦ-ны анхдагч зах зээлийн арилжаатай холбогдон гарсан аливаа санал гомдлыг энэхүү заавар болон МХБ-ийн хяналтын журам"-ын дагуу шийдвэрлэнэ.